

**“ЦЭНГАЗАР” ХХК – ИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАЙШИР СУМЫН ХУРИМТ
БАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ДӨРВӨЛЖИН ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ АРГААР
АШИГЛАХ, ШОХОЙ ЦЕМЕНТИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



АШИГТ МАЛТМАЛЫН ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-017689

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5086353

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

“ЦЭНГАЗАР” ХХК ҮЙЛДВЭРИЙН ЗАХИРАЛ

Д.МӨНГӨНЧИМЭГ

М.БАТСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

“ЦЭНГАЗАР” ХХК БО МЭРГЭЖИЛТЭН

Г.БИЛЭГСАЙХАН

Гарчиг

ОРШИЛ	3
ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:	4
ТӨСЛИЙН ЗОРИЛГО:	4
ТӨСЛИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН АЧ ХОЛБОГДОЛ:.....	5
ТӨСЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ:	5
ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ.....	7
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ	10
2025 ОНЫ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	11
2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөөг хэрэгжүүлэхэд гарсан нийт зардал	12

ОРШИЛ

Монгол Улсын баруун бүс, түүний дотор Говь-Алтай аймгийн эдийн засгийн хөгжилд түлхэц оруулах, шинэ ажлын байр бий болгох, импортыг орлох, экспортод чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл бий болгох, зорилгоор тус аймгийн Тайшир сумын нутаг дэвсгэрт байрлах Дөрвөлжингийн шохойн чулууны ордын тусгай зөвшөөрлийг эзэмшигч “Цэнгазар” ХХК нь (Улсын бүртгэлийн дугаар 9011060149) ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй бөгөөд Дөрвөлжингийн шохойн чулууны ордын MV-017689 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМТ-гаас 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдөр олгосон байна.

Өнөөгийн байдлаар үйлдвэрийн барилгын ажил 95%-тай явагдаж байгаа бөгөөд 2025 оны 4-р улиралд ашиглалтанд оруулахаар төлөвлөгдөж байна.

Хэдийгээр тус үйлдвэрийн үйл ажиллагаа барилгын шатанд явж байгаа хэдий ч 2024 оны 3 сард БОМТ-г батлуулан хэрэгжүүлэв. 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 19-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн бодлого, Үйлдвэржилтийн бодлого, Эдийн засгийг сэргээх хөтөлбөр, Засгийн газрын “21:100” хөтөлбөрт баруун бүс нутагт барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлийн хүрээнд уг төсөл хэрэгжиж байна.

Нийслэл Улаанбаатар хотоос 1000 гаруй км-ээр алслагдсан байдал нь баруун таван аймгийн барилгын салбарыг тээврийн зардал, үнийн өсөлт зэрэг нь дэд бүтэц болон эдийн засгийн салбаруудыг хөгжүүлэх, шинээр ажлын байр нэмэгдүүлэх, техник технологийг шинэчлэн сайжруулах боломжийг нь хязгаарлаж байна.

Төслийн нэр:	Дөрвөлжин шохойн чулуун ордыг ил аргаар ашиглах төсөл
Төслийн хүчин чадал:	Жилд 120.000 тонн шохойн чулуу олборлох хүчин чадалтай
Байршил:	Говь-Алтай аймгийн Тайшир сум, Хуримт баг
Хаяг:	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Самбуугийн гудамж, М Плаза 1602 тоот
Хариуцах хүн:	Байгаль орчны ажилтан Г.Билэгсайхан Утас: 88483839
БОННУ хийсэн	“Эх монголын байгаль” ХХК

ААН-ийн нэр

Батлуулсан огноо: 2022 он

2025 оны 10 сарын сүүлийн байдлаар

ДӨРВӨЛЖИН ШОХОЙН ЧУЛУУНЫ УУРХАЙН 2025 ОНЫ ТАЙЛАН		
Уурхайгаас олборлох түүхий эд	Түүхий эд	Нийт
	Нийт шохойн чулуу, Эзэлхүүн мян.м3	7.879
	Шимт хөрс Талбай /га/ Эзэлхүүн / мян.м3/	0.3
	Нийт уулын цул /мян.м3/	8.6

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Монгол Улсын Баруун бүсийн аймгууд буюу Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын бүтээн байгуулалт руу чиглэж байгаа бөгөөд 2020 оноос эхэлсэн баруун бүсийн бүхий л бүтээн байгуулалтын ажлуудад нийлүүлэх;
- МУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу байгалийн баялгийг эдийн засгийн хувьд үр ашигтайгаар, зохистой ашиглаж,

дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, технологийн горимыг нарийн чанд баримталж, байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээлт хийх;

- Шинээр ажлын байр бий болгох, бүсийн эдийн засгийн хөгжилд үлэмж түлхэц болох

ТӨСЛИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН АЧ ХОЛБОГДОЛ:

Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутаг дэвсгэрт байрлах шохойн чулууны “Дөрвөлжин” ордыг ил аргаар олборлон хуурай аргын цемент, шохойн цогцолбор үйлдвэрийг ашиглалтанд оруулснаар орон нутагт тогтвортой ажлын байр бий болгож, бүс нутагт дэд бүтэцийн нэгжийн үнийг үлэмж багасгах, баруун бүс нутгийн эдийн засгийн хөгжилд түлхэц томоохон хувь нэмэр болно. Төслийн хугацаанд нийт 108.4 тэрбум төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ба энэ нь жилд дунджаар 5.4 тэрбум төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлж байна.

ТӨСЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ:

Тус төсөл нь 2023 оны 5 сараас барилга угсралтын ажил эхэлсэн бөгөөд 95%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Одоогийн байдлаар төмөр бетон цутгалтын үндсэн ажлууд болон тоног төхөөрөмж угсралтын ажил хийгдэж байна. Бүрэн хүчин чадлаараа ашиглалтанд орох хугацаа хараахан дуусаагүй бөгөөд 2025 оны 4-р улиралд багтаан дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

Зураг 1



2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1 Дөрвөлжингийн шохойн чулууны орд нь Монгол Улсын баруун хэсэгт, Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутагт байрладаг. Уг орд нь Улаанбаатар хотоос баруун тийш 1,020 км, Говь-Алтай аймгийн төв Алтай хотоос зүүн хойш 40 км, Тайшир сумын төвөөс баруун урагш 7 км-т байрлана.

Хүснэгт 1

№	Өргөрөг			Уртгаг			№	Өргөрөг			Уртгаг		
MV-017689 Шохойн чулууны орд							Шохойн үйлдвэр /24 га/						
1	96	30	0,19	46	38	0	1	96	29	22,17	46	39	1,17
2	96	27	20,09	46	38	0	2	96	30	0,18	46	39	1,17
3	96	27	20,1	46	38	51,57	3	96	30	0,18	46	38	51,57
4	96	30	0,19	46	38	51,57	4	96	29	22,17	46	38	51,57

2.2. *Физик газар зүйн мужлалаар:* Говийн их муж буюу Алтайн ар говийн нуурын хөндийн тойрогт байрладаг. Монгол Алтайн нурууны хойд талд Хантайшир, Хасагт хайрхны нурууны (3,578.0 м) Зост Өндөр уулын (3,311.0 м) зүүн талд, Таван Хайрхан уулаас (2,037.0 м) баруун тийш, Дулаан хар уулаас (2,419.0 м) урагш Цагаан Оломын өргөрөгт байрлах ба ерөнхийдөө баруун хойноос зүүн урагшаа чиглэн сунаж тогтсон цувраа жижиг дэл нуруу, жижиг дов, намхан гүвээрхэг, толгод тал хөндийгөөс бүрдэх бөгөөд далайн түвшнээс дээш 1,760-1,860 м-т өргөгдсөн. Тусгай зөвшөөрлийн талбайн хамгийн өндөрлөг цэг нь талбайн баруун хойд болон зүүн урд хэсэгт байрлах 1,853.0 м, 1,828.0 м өндөрлөгүүд ба хамгийн нам дор цэг нь талбайн зүүн хойд хэсэгт байрлана. Гадаргын харьцангуй өндөр нь 80-100 м байна.

2.3 *Хөрс, ургамал:* Хөрс-газарзүйн мужлалаар Говийн их муж, хөрсний бүсчлэлийн хэв шинжээр хотгорын бүсшилтэй нутагт Монголын өрнөд мужид нууруудын хөндийн тойрогт багтана. Ихэнх хувьд нь хээрийн ба хуурай хээрийн ухаа, толгод, тал хөндийн цайвар хүрэн хөрс, хүрэн өнгийн элсэрхэг хөрс тархсан. Хур чийг багатай хавар, зуны улиралд их салхитай халуун учир хөрс үүсэх үйл явц удаан ургамлын бүрхэвч доройтон газрын хөрс нь ихээр элэгдэж, үерийн усанд эвдрэх байдал сайранд илүү ажиглагдана. Хөрсний дээд давхарга дахь чулуу их, ургамал нь тачир сийрэг учир хөрсөнд орох ялзмагийн хэмжээ багатай.

Ургамал-газарзүйн мужлалаар: Төв Азийн муж тал, талархуу нуурын хөндийн газарт хамаарагдана. Ургамлын бүрхэвч нь тачир сийрэгдүү ургадаг байна. Талбайн дов толгод болон түүний жалга судаг сайруудыг дагаж алаг өвс, хялгана, бударгана, ботууль, баглуурт бударгана ургана.


2.4. *Ан, амьтан:* Орд нь Монгол Алтайн нурууны хойд хэсгийн мужид хамаарагдах бөгөөд энэ нутаг нь дэлхийд нэн ховордсон улаан номд орсон аргал, янгир, шилүүс, ирвэс зэрэг дархан цаазат амьтад байдаг. Үнэг, чоно, мануул зэрэг үслэг амьтадтай. Мэрэгчээс зараа, монгол огдой, шар чичүүл, туулай, говийн алаг даага зэрэг тохиолдох ба жигүүртэн шувуудаас бор болжмор, хон хэрээ, бүргэд, ёл, тас, шар шувуу, сар, элээ, улаан номд орсон хар өрөв тас, хээрийн галуу, цахлай амьдрах ба зарим нь дайран өнгөрдөг.

Дэд бүтэц, хүн ам: Тайшир сумын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал

Тус сум нь 2020 оны жилийн өрх, хүн амын тооллогоор Хуримт, Далан, Галуут гэсэн 3 багийн нийт 474 өрхийн 1649 суурин хүн амтай. Тайшир сумын эдийн засгийн хөгжилд Хөдөө аж ахуйн салбар тэргүүлэх байр суурийг эзэлсээр ирсэн ба цаашид ч хөгжүүлэх бодлого чиглэлийг баримталж байна. Сумын хэмжээнд 427 өрх малтай бөгөөд үүнээс 340 нь малчин өрх байна.

Төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах бодлого, төсөл хэрэгжих орчны нийгмийн асуудлыг шийдэх цогц бодлого баримтлан ажиллахаар төлөвлөж байна.

Зураг 2



Зураг1 Дөрвөлжин MV-017689 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн болон шохой үйлдвэрийн талбайн байрлал

ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Хүснэгт 2-т төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлэх нөлөөллүүдийн үнэлгээг танилцуулж байна.

Хүснэгт 2

Нөлөөллийн төрөл	Эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал	Нийт оноо	Онооны эзлэх хувь%	Нөлөөллийн зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт							
Усны чанарын өөрчлөлт	2	3	1	2	8	32	Дунд
Ургамлын бүтцийн өөрчлөлт	3	5	1	4	13	52	Дунд
Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдол	2	5	1	3	11	44	Дунд
Геологийн тогтцын өөрчлөлт	2	5	1	5	11	44	Дунд
Зэрлэг, ан амьтдын орон зайн өөрчлөлт	1	5	1	2	7	28	Бага
Агаарын орчин/бохирдол/	8	5	1	4	16	64	Дунд
Газар доорх усны нөөц	6	4	2	3	15	60	Дунд
Дундаж						46,2	Дунд
2. Байгалийн нөөцийн ашиглалт							
Газрын гадаргын нөөц баялаг	1	5	1	1	8	36	Дунд
Бэлчээр тэжээлийн байдал	2	5	1	1	6	24	Бага
Эрдэс түүхий эдийн нөөц	6	5	2	2	15	60	Дунд
Дундаж						38,67	Дунд
3. Байгаль орчны чанар, нийгмийн өөрчлөлт							

Ундны усны чанар, хэмжээ	4	4	1	2	11	44	Дунд
Хөрсний бохирдол	2	3	1	2	8	32	Дунд
Агаарын чанар	8	5	1	4	16	64	Дунд
Дуу чимээ, шуугиан	2	5	1	2	10	40	Дунд
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+						+
Орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлөх	+						+
Дундаж						30,0	Бага
4. Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт давхаргад үзүүлэх нөлөөлөл							
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	-	-	-	-	-	-	-
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	-	-	-	-	-	-	-
Тусгай хамгаалалттай ба цогцолбор газарт нөлөөлөх	-	-	-	-	-	-	-
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	4	4	1	3	12	48	Дунд
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх	6	4	1	4	15	60	Дунд
Дундаж						21,6	Бага
5. Бусад нөлөөлөл							
Тээвэрлэлтээс шалтгаалан хөрс эвдрэх	2	2	1	2	7	28	Бага
Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгалаас шалтгаалан үнэр гарах, шавьж үржих	2	1	1	2	6	24	Бага
Хүчтэй салхи, түймэр, газар хөдлөлт, аянга	2	1	1	2	6	24	Бага
Дундаж						25,3	Бага
Үр дүн /ерөнхий дундаж/						29,45	Бага

Хуримтлагдах нөлөөллийн тодорхойлолтууд: Байгаль орчны үнэлгээний гол шалгуурууд болон урьдчилан тодорхойлсон үүсч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг дараах хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 3

Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд	Сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй нөхцөлүүд
Төслийн байршилтай холбоотой шалгуурууд	
Хүний нөлөө болон байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, эсэх	Орон нутагт салхины нөлөө ихтэй ба хүчтэй шуурга үе үе болдог. Ил уурхайн олборлолтын технологийн үе шатуудаас болон шохойн үйлдвэрийн үйл ажиллагаанаас богино хугацаанд эрчим ихтэй тоосжилт үүсч болзошгүй. Газар хөдлөлтийн 8 баллын бүсд оршиж байгаа.

Орон нутгийн хэтийн хөгжил ашиглахаар төлөвлөсөн газар байгаа эсэх	Тайшир сумын усан цахилгаан станц 12 км-ийн зайд оршдог. Тайшир суманд болон төслийн талбайд ойр орших улсын тусгай хамгаалалттай болон тусгай хэрэгцээний газар байхгүй.
Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсэх эсэх	Орон зайн хувьд нөлөөллийн цар хүрээ цаашид тэлэхгүй бөгөөд харин төсөл хэрэгжих явцад өөр төслүүд зэрэгцүүлэн хэрэгжүүлэх үед хуримтлагдах нөлөөлөл үүсч болзошгүй.
Тусгай хамгаалалттай газар нутаг түүх соёлын зүйлүүдэд нөлөөлөл үүсэх эсэх	Тайшир сум болон төсөл хэрэгжих талбайн орчимд улсын тусгай хамгаалалттай газар байхгүй. Төслийн талбайд хамгийн ойр орон нутгийн тусгай хамгаалалттай газар нь хойт зүгт 1.5 км зайд Долоон тогой, Сэнжин хад нэртэй байгаль түүхийн дурсгалт газар байдаг.
	Дөрвөлжин шохойн чулууны ордын ашиглалтын талбайд 36 ширхэг хүний гараар бүтсэн чулуун байгууламжууд бий.

2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, БОННУ-н дэх зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төслийн үйл ажиллагаанаас үүсч буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсч болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой. Тиймээс төслийн бүтээн байгуулалт болон үйл ажиллагааны явцад үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзээд холбогдох зардлыг төлөвлөв. Энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлнэ. БОМТ-г хэрэгжүүлэхэд төсөл хэрэгжүүлэгч дараах бодлогыг баримтална. Үүнд:

- БОМТ нь төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн боломж нөөцтэй уялдсан байх.
- БОМТ-ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх.

Хүснэгт 4. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Д/Д	Бүрэлдэхүүн хэсгүүд	Төсөв /мян.т/	Тайлбар
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан	2720.0	
2.	Нөхөн сэргээлтийн тайлан	10320.0	
3.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний тайлан	-	Дотоод төлөвлөлтөөр
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний тайлан	-	Дотоод төлөвлөлтөөр
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний тайлан	-	Дотоод төлөвлөлтөөр
6.	Осол, эрсдэлийн менежментийн тайлан	-	Дотоод төлөвлөлтөөр
7.	Химийн бодисын эрсдэлийн менежментийн тайлан	1950.0	Дотоод төлөвлөлтөөр
8.	Хог хаягдлын менежментийн тайлан	1580.0	
9.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1958.0	
10.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын тайлан	-	Дотоод төлөвлөлтөөр
11.	Төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	1200.0	
2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн төсөв		19728.0	

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоход уурхайн явцад газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал,

агаар орчин бохирдох, хүний эрүүл мэнд зэрэгт сөргөөр нөлөөлөх нь тогтоогдсон. Иймд төслийг хэрэгжүүлэх үед үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг авч ажилласан.

3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Төслийн агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахын тулд дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагаанд ашиглах машин механизмуудын утаат яндангаас ялгарах хорт хийн агууламжийг бууруулах зорилгоор утааны янданг тусгай шүүлтүүрээр тоноглохын зэрэгцээ техникийн оношлогоо, тохиргоо, үйлчилгээг тогтмол хийж, ашиглалтын нөхцөлийг сайжруулах замаар агаарын бохирдлыг багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

- Мөн уурхайн задгай талбайд олборлолтын үйл ажиллагаагаар ялгарах тоосны хэмжээг бууруулахын тулд задгай талбайг усалж, чийгтэй байлгах арга хэмжээ авах, аль болох богино хугацаанд нөхөн сэргээлт хийж байсан.

- Уурхайн шимт хөрсний болон гадаад овоолгын талбайг хуурай, салхи ихтэй, агаар мандал тогтворгүй үед байнга усалж байсан.

3.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Шохойн чулуу олборлох уурхайн төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Төслийн явцад хөрсийг ахуйн ба үйлдвэрлэлийн хог хаягдал болон нефтийн бүтээгдэхүүнээр бохирдохоос урьдчилан сэргийлж ажилласан.

- Уурхайгаас гарах шороог төслийн дагуу овоолгын талбайд зөв байрлуулан асгаж, дагтаршуулах, хур тунадас, салхины нөлөөгөөр үүсэх хагарал, хотойлт зэргийн шалтгааныг судалж түүнээс урьдчилан сэргийлж ажилласан.

- Бүтээгдэхүүн тээвэрлэх машины зөөвөрлөх талбайд орох, гарах маршрутыг нарийвчлан тогтоох, олон салаа зам гаргахгүй байх, машин механизмын үзлэг үйлчилгээ хийх талбайг тогтоож, тэнд хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан.

- Авто засварын газрын талбайг тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж, цардаж өнгөлж, тэмдэгжүүлж ажилласан.

- Уурхайн олборлолт, барилга байгууламж байгуулах явцад эвдэрсэн хөрсийг засч тэгшлэх, нөхөн сэргээх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлсэн.

- Хөрс хадгалах зориулалттай талбайг сонгохдоо салхи, усны нөлөөгөөр хөрс элэгдэл дорох нөхцлийг хамгийн бага байхаар төлөвлөж хийсэн.

- Шимт хөрсийг хамгаалахын тулд овоолгын өнгөн хэсгийг сэргээх, үүний тулд овоолгын гадаргуугийн хөрсөнд усалгаа хийсэн

3.3 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

- Газрын доорх ус буюу ундны усны нөөцийг бохирдуулагч эх үүсвэр нь хөрсний бохирдол юм. Хөрсөн дээр асгарсан, гоожсон шатах, тослох материал түүний үе давхаргуудад

шүүрэн нэвчиж газрын доорх усыг бохирдуулна. Нөгөө талаар бороо хурын ус чийг, хөрсөнд бий болсон дээрх бохирдлуудыг цааш дамжихад ихээхэн нөлөөлөлтэй байдаг тул нэн түрүүн хөрсийг шатах, тослох материалаар бохирдохоос урьдчилан сэргийлж ажилласан.

- Өөрийн ашиглалтын талбай дахь болон эргэн тойрны хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулсан.

- Ажилчид болон төслийн талбай түүний нөлөөллийн бүсэд байх талбай дахь ард иргэдийн унд ахуйн хэрэгцээний усны чанар нь стандарт, норм, нормативд нийцэхийг шалгаж улиралд 1 удаа шинжилгээнд хамруулсан.

3.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Төслийн явцад ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах замаар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Ашиглалтын талбайн ургамал бүрхэвчийг хамгаалах үүднээс олон салаа зам гаргахгүй байх үүднээс 1.27 км урттай, 12 м өргөнтэй далан байгуулж, сайжруулсан зам тависан.

- Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх үүднээс хогийн нэгдсэн цэг байгуулсан.

- Ногоон байгууламж барих, 2000 ш мод тарьсан.

3.5 Шимт хөрс хуулалт хадгалалт

Төсөл нь байгалийн бүс бүслүүрийн ангилалаар говь цөлийн бүсэд хамаарах бөгөөд уг бүслүүрт говийн бор, говийн цайвар бор, цөлийн бор саарал, борзон хөрс зонхилон тархдаг бөгөөд шимт хөрсийг тухай бүс бүслүүрийн онцлогоос хамааруулан 20 см-ээр MNS 5916:2008 стандарт шаардлагын дагуу хуулж хадгалсан.

Үржил шимт хөрсний овоолгыг үүсгэх болон хадгалахад дор дурьдсан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

- Үржил шимт хөрс хуулалтыг стандартын дагуу хийх технологийг ажилтан, машин механизмын жолооч нарт эзэмшүүлсэн.

- Шимт хөрсний овоолгыг газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008 стандартын дагуу хуулж, хадгалсан.

- Шимт хөрсний овоолгыг салхинд хийсэх, усанд автах, хужиртах, хатуу биет, чулуу, барилгын болон хаягдалд дарагдаж бохирдохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн. Тухайлбал үржил шимт хөрсний овоолгыг олон дахин зөөхгүйгээр тогтвортой хадгалах талбайд байршуулсан. Усанд урсахааргүй газарт байршуулсан.

- Шимт хөрсний овоолгын байршил, хэлбэр, хэмжээ нь түүний хамгийн сайн хадгалагдах нөхцөлийг хангасан байхаар хэлбэршүүлэх бөгөөд шимт хөрсний овоолгын өндрийг 5 метрээс илүүгүй байхаар үүсгэхэд 0.48 га талбайг эзэлж байна.

- Шимт хөрсийг салхины зонхилох чиглэлийн дагуу шимт хөрсний овоолгын гадна талаар салхиар тоос шороо дэгдэн, шимт хөрс алдагдахаас сэргийлж хашаа хамгаалалт хийж,

овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлэн олон наст өвслөг ургамал тарьж хашаа хамгаалалт хийсэн.

- Шимт хөрсний хадгалалт, хамгаалалт, тордолгоо, бүртгэл, хяналтын ажлыг байнга хэрэгжүүлсэн.


Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан

Энэхүү сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө нь “Цэнгазар” ХХК -ийн “Дөрвөлжин” шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах, шохой үйлдвэрлэх төслийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө бөгөөд доорх хүснэгтэд тусгагдсан арга хэмжээг жил бүр хэрэгжүүлэн ажиллахаас гадна тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд нэг бүрчлэн тусгаж, биелэлтийн тайланд хэрэгжилтийн хэмжээ гүйцэтгэлийн талаар тодорхой тусгаж тайлагнаж байна.


Тухайн төслөөс үүсэх гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлсны үндсэн дээр сөрөг нөлөөллийг хэрхэн бууруулах талаар ерөнхий төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлсэн биелэлтийн тайланг хугацаа болон зардал мөнгөтэй нь доорх хүснэгтээр үзүүллээ.


СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан


Байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Байгаль орчныг хамгаалахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэгч	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нийт зардал \мян.төг\	Зураг
1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө							
Салхи шуурга ихтэй үед ордын ашиглалтын талбайгаас тоос босч орчны агаарт бохирдол үүсгэнэ Хөрсний чийг бага, салхины хурд их үед агаар дахь тоосны хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэх үндэслэлтэй	1.1 Тоосны дэгдэлтийг бууруулах зорилгоор усалгаа хийж тоосжилтыг бууруулах арга хэмжээ авах	Үйлдвэрийн гадна болон доторх талбайн зам услах маршрут, уурхайн технологийн зам услах маршрутыг гаргаж батлуулан зам усалсан. Зам усалгааны бүртгэл хөтөлж хяналт тавьж ажилласан.	Ил уурхай, барилгын ажил	ХЭМАБ, БО, Уурхай, кемп аж ахуй	3-11 сар хүртэл өдөрт 2 удаа	Ү/ажиллаг ааны дотоод зардлаар	
	1.2 Хурдны хязгаар 40км/ц- аас хэтрэхгүй байхаар хязгаарлах зааварчилгаа өгч, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, зам талбайн усалгаа, хийх	Автогридерээр замыг тэгшилж, засаж, усалгааг 14 хоног дутамд хийдэг.	Уурхайн дотоод, гадаад зам талбай	Уурхай болон Үйлдвэр	Сард 2 удаа	700.0	
	1.3 Тоосжилт үүсэхээс сэргийлж хурдны хязгаарлалтыг уурхайн GPS-н мэдээнд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд хурдны тэмдэг байрлуулах,	Уурхайн техникүүдийн GPS-ийн мэдээгээр цаг тутамд хяналт тавин ажиллаж байна. Үйлдвэрийн бүс, технологийн замд зорчиж байгаа техникүүдэд хурд хэмжигчээр хяналт	Уурхайн бүх, хэлтэс, нэгж, техникүүд	ХЭМАБ-ын мэргэжилтэн	Жилийн турш	Ү/ажиллаг ааны дотоод зардлаар	

	хүчтэй салхи шуургатай үед ажлыг түр зогсоох.	тавин норм, шаардлагад нийцүүлж байна. 2025 оны 4, 5, 10 сард Цаг агаарын нөхцөл байдал үзэгдэх орчин хязгаарлагдмал салхины хурд 18-20м/сек хурдтай байсан байна.					
	1.4 Үйлдвэрийн тоос барих үндсэн төхөөрөмжийн ханцуй 2365 ш шинээр суурилуулсан	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас тоосжилт үүсэхээс урьдчилан сэргийлж 13BF04, 13BF10, 13BF13, 18BF03 – 454 ширхэг, 10BF09, 10BF11, 12BF06, 19BF12, 19BF01 – 420 ширхэг, 27BH06 – 420 ширхэг, 22BF02 – 464 ширхэг, 26BF10 – 187 ширхэг, 28BF05, 28BF07, 28BF09, 28BF11 – 420 ширхэг шинээр суурилуулсан	Үйлдвэрийн бүсэд.	Үйлдвэрлэл засвар механикын хэсэг ХЭМАБ,Б О	Жилийн турш	Ү/ажиллаг ааны дотоод зардлаар	
Эрүүл ахуйн шаардлага хангах, үнэрийн бохирдол тархах	1.5 Хогийн цэгийн ойр орчмыг дулааны улиралд ялаа, шавж, бактери үржих, үнэрийн бохирдол тархахаас урьдчилан сэргийлж ариутгал хийх	Хөрсний бохирдол, үнэрийн бохирдол, халдварт нян үүсэхээс сэргийлж ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг мэргэжлийн байгууллага болох “Ариусгал Алтай” ХХК-тай 2025 онд байгуулсан гэрээний дагуу хогийн цэгийн ойр орчим, бие засах	Үйлдвэрийн бүсэд.	Кемп аж ахуй	Улирал тутамд	1200.0	


		газар, бохирын цооног, нийтийн эзэмшлийн газар бүрт улирал тутам ариутгал, халдваргүйжүүлэлт хийж байна.					 
Уурхай болон үйлдвэрийн ажил болон машин механизмын хөдөлгөөний улмаас хүрээлэн буй орчин дахь шуугианы бохирдлын түвшинг ихсэж физик нөлөөлөл үүснэ.	1.6 Ажлын байранд чихний бөглөөс болон хамгаалалтын чихэвч байнга хэрэглэж байх	Чихний бөглөөг ажлын байрны нөхцөлөөс шалтгаалан өдөр тутамдаа хэрэглэж байна. 300 ширхэг чихний бөглөө захиалснаас 275 ш бөглөөсийг хэрэглэсэн байна.	Төслийн талбай болон үйлдвэрийн гадаад болон дотоод орчинд	ХЭМАБ-ын мэргэжилтэн	Төслийн хугацаанд	ҮАЗ-д тусгасан.	
Уурын зуухны яндангаас агаарт бохирдуулагч хий цацагдаж, агаар орчныг бохирдуулах	1.7 Уурын зуухны технологид тохирсон нүүрс хэрэглэх, засвар үйлчилгээг тухай бүр хийх, бохирдуулагчийн ялгарлыг шүүж, стандарт хэмжээнд барих шүүлтүүр ашиглах	2025 онд уурын зуухны бүтээн байгуулалт хийгдээгүй. Үйлдвэрийн талбайд хийгдэх уурын зуухны зураг төсөлд утааны хэсгийн замд утаа шүүх шүүлтүүрийг суурьлуулахаар төлөвлөгдсөн болно	Үйлдвэрийн бүсэд.	Кемп аж ахуй	Төслийн хугацаанд	ҮАЗ-д тусгасан.	
Зардал						820.0	

2. Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө							
Хөрс хуулалт хийх, зам талбай гаргах, төслийн талбайн үйл ажиллагааны үед тухайн орчны өнгөн хөрс элэгдэх, үржил шимт чанар нь алдагдах	2.1. Шимт болон шимэрхэг хөрсийг алдагдахаас хамгаалж хадгалах талбайг зөв тодорхойлох, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих (3 метрээс өндөргүй овоолох, 60 метр тутамд 8 метр өргөнтэй зам үлдээх)	10 - 15см-н зузаантай 564 м2 газар 450 м3 шимт хөрс хуулсан. Ил уурхайн шохойн чулуун тогтоц нь өнгөн хэсэг дээр тул шимт хөрс бага хөндөгдсөн.	Нийт төслийн хэмжээнд	БО мэргэжилтэн, уурхай	Төслийн нийт хугацаанд	1000.0	
Хүнд, машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарч, хөрсний шороо суларч, элэгдэл эвдрэлд өртөх талбайн хэмжээ нэмэгдэж болзошгүй Төслийн талбайн хөрс, газрын гадарга олон машин техникийн нөлөөгөөр талхлагдах, олон салаа зам үүсэх сөрөг нөлөөлөлтэй.	2.2. Төлөвлөлтөөс гадуурх талбайд нүх ухах, зам талбай үүсгэх зэргээр хөрсний элэгдэл эвдрэлд орохоос сэргийлж, инженер техникийн ажилчдад анхааруулж байх, түүнд хяналт тавих.	Төлөвлөлтөөс гадуурх талбайд нүх ухах, зам талбай үүсгэх зэргээр хөрсний элэгдэл эвдрэлд орохоос сэргийлж, инженер техникийн ажилчдад 2 удаагийн сургалт орсон.	Үйлдвэрийн ба уурхайн бүсэд	Хэлтэс нэгжүүд	Тухай бүрд	Шаардлаг агүй	
Бензин, тос, дизель (шатах тослох материал) зэргийн асгаралт, ахуйн хэрэглээний хог хаягдлаас хөрсний бохирдол үүсэх.	2.3. Асгарсан тос, маслоор бохирдсон хөрсийг хадгалах, саармагжуулах цэг хийх.	2025 онд ШТС байгууламжийн зураг төслийг хийлгэсэн бөгөөд тус зурагт БНБД дагуу бетон талбайг төлөвлөж барилга угсралтыг эхлүүлээд байна	Үйлдвэрийн дотоод орчинд	ХЭМАБ, БО	Тухай бүрд	ҮАЗ-д тусгасан.	

Хөрсний болзошгүй бохирдол	2.4 Шороон замыг засаж сайжруулах	Ил уурхайгаас үйлдвэр хүртэлх 1.4 км далан суурьтай сайжруулсан автозамыг хийсэн	Ил уурхай, үйлдвэрийн орчинд	Уурхай, гэрээт компани	Жилд	ҮАЗ-д тусгасан.	
Зардал						1000.0	
3. Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө							
Төслийн усны хэрэглээнээс газар доорх усны нөөцийн хомсдол үүсэх	3.1 Усны зохистой ашиглалтын талаар сургалт орох Дэлхийн усны өдрийг тэмдэглэж өнгөрөөх	2025 оны 3 сарын 21-нд усны өдрийг тохиолдуулан усыг хайрлах, гамнаж хэрэглэх талаар сургалт орж, Цэнхэр алт усаа хайрлая сэдвийн доор АХА тэмцээн зохион байгуулсан.	Үйлдвэрийн н бүсэд	Сургалтан д хамрагдсан хүний тоо	Жил бүр	ҮАЗ-д тусгасан.	
	3.2 Холбогдох газруудаар ус ашигласны болон ус бохирдуулсаны дүгнэлт гаргуулан зөвшөөрөл авч, гэрээ байгуулж, төлбөрийг төлөх	Говь-Алтай аймгийн БО-ны газраас усны дүгнэлт гаргуулж Тайшир сумтай ус ашиглах гэрээ болон зөвшөөрлийг авч төлбөрийг нь нэхэмжлэлийн дагуу хугацаанд нь төлж барагдуулсан.	Үйлдвэрийн н бүсэд	Химич болон БО мэргэжилт нүүд	Жил бүр	ҮАЗ-д тусгасан.	

	3.3 Усны эх үүсвэр дээр тоолуур суурилуулах, тоолуур баталгаажуулах	Сумын ногоон байгууламжийн худагт СХЗ-н төвөөр баталгаажуулсан тоолуур суурилуулсан	Унд ахуйн худаг	Сантехник	II улирлад	300.0	
Усны сан бүхий газар, түүний онцгой хамгаалалтын бүс, унд ахуйн худгийн эрүүл ахуйн бүс хог хаягдлаар бохирдох, уурхайн үйл ажиллагаанд өртөх.	3.4 Завхан голын ус авдаг хэсгийг автомашины зогсоолтой болгох	11 сард төлөвлөгөөнд тусгаж оруулсан Худаг уст цэгийн хангамжийг сайжруулах бохирдолоос хамгаалах үүднээс байгууламжийг мөн хийж өгсөн	Завхан гол дагуу	БО мэргэжилтэн, кемп аж ахуй	IV улиралд	0	 
Хур бороо, үерийн усаар төслийн талбай дахь хог хаягдал, шатах тослох материалын үлдэгдэл угаагдан хөрсөнд нэвчиж улмаар газрын доорх усны чанар, найрлагад өөрчлөлт оруулж бохирдуулах	3.5 Шатах тослох материал алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд болон машин техникийн бүрэн бүтэн байдал, хог хаягдлын хадгалалтад тогтмол хяналт тавих, асгарч алдагдсан тохиолдолд ашиглах шаардагдах хэрэгсэл, материалыг бэлтгэх, бэлэн байлгах	Усны чанарын шинжилгээг завхан гол, цэвэршүүлсэн ус, Баарангийн худаг, гал тогоо гэх мэт 4 цэгээс дээж авч Говь-Алтай аймгийн аймгийн Стандарт хэмжилзүйн сорилтын лабораторид улиралд 1 удаа шинжилгээ хийлгэдэг. Хаягдал усны чанарын шинжилгээг улиралд 1 удаа Говь-Алтай аймгийн Стандарт хэмжилзүйн сорилтын лабораторид хийлгэж байна.	Үйлдвэр болон уурхайн хэмжээнд	ШТС нярав, БО мэргэжилтэн	Жил бүр	600.0	


Зардал						900.0	
4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө							
Газар шорооны ажил болон машин техникийн хөдөлгөөнөөр орчны ургамлан нөмрөгт нөлөөлөл үзүүлнэ. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	4.1. Өмнө жилүүдэд суулгасан модны суулгацын усалгаа, арчилгааг улиралын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх	Үйлдвэрийн талбайн хэмжээнд ургаж байгаа модны тогоог элсэнд дарагдах бүр сэргээн засварлаж Хаврын мод нахиалалт ургалтын үеэр хэлбэржүүлэлт хийдэг, нийт 2000 ш мод таригдсан.	Нийт төслийн хэмжээнд	БО мэргэжилтэн	Төслийн хугацаанд хэрэгжүүлэн ажиллах	2500.0	
	4.2 Нутгийн үрийн фонд бий болгож стандартын дагуу хадгалах, мөн ховор ургамлын үр түүж цуглуулах, нөхөн сэргээлтэнд ашиглах	2025 онд 2-3 наст улиаснаас 100 гаруй ширхэг улиасны тарьцыг энгийн орчинд тарьж ургалтыг туршихад, амьдралтын хувь 95 байсан бөгөөд намрын тариалалтын өдрөөр кемпийн мод тарих талбайд суулгацыг тарив. Шар хуайс, хайлаасны 2 орчим кг үр түүж бэлтгээд байна.	Үйлдвэр болон уурхайн хэмжээнд	БО хэсэг	2025 он	Шаардлаг агүй	
Зардал						2500.0	
5. Амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө							
Цахилгааны шугамууд дээр суусан махчин шувууд тогонд зохиулж үхэх, тоо толгой цөөрөх нөлөөлөл үүсэж болзошгүй.	5.2 Агаарын шугамууд болон 35 кВ ил хувиарлах байгууламжын портал дээр шувуу үргээгч 46 тулгуурт байршуулах	Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугаманд 2025 онд 138 ш шувуу үргээгч хийгдснээр төслийн үйл ажиллагаанаас шувуу зүй бусаар хорогдох явдал гарахгүй юм.	Төслийн талбайн хэмжээнд	БО мэргэжилтэн, цахилгааны инженер	2025 он	ҮАЗ-д тусгасан.	

Зардал					0	
6. Оршин суугчид болон ажиллагсдын эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал						
Үйлдвэрийн бутлалт, тээрэмдэлт, шатаах системийн хэсэгт ажиллах ажилчид тоосжилт, дуу чимээ ихтэй, температурын эрс өөрчлөлттэй ерөнхийдөө хүрээлэн буй орчны физик бохирдолттой хөдөлмөрийн хүндэвтэр нөхцөлд ажиллах тул мэргэжлээс шалтгаалах өвчлөлд хялбар өртөж болзошгүй юм.	6.1. Ажилтнуудын эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулах.	Эрүүл мэндийн сайдын А340-р тушаалын дагуу “Кардиофловёр” компанийн Повермед эмнэлэгт хөдөлмөрийн эрүүл мэндийн эмнэлэгийн эрүүл мэндийн хугацаат үзлэг хийгдсэн. Үзлэг, шинжилгээнд нийт 60 ажилтан хамрагдсан.	Төслийн уурхай болон үйлдвэрийн ажилчид	“Цэнгазар” ХХК	Жил бүр	
	6.2. Ажилтнуудын дунд тохиолдож буй өвчлөлийг тодорхойлох, улирал, цаг хугацаагаар судалгаа хийх	2025 оны 1 сараас 11 сар хүртэл эмнэлгээр 928 хүн анхан болон давтан үзлэгт хамрагдсан. Үүнээс 1-4 саруудад: Амьсгалын замын өвчлөл, үе мөч, бөөр шээсний замын өвчлөлт, зүрх судасны өвчин, хоол боловсруулах эрхтэний тогтолцоо зэрэг өвчлөл зонхилж 478-н ажилтан үзлэгт хамрагдсан 5-9 саруудад: Зүрх судас, хоол боловсруулах эрхтэн тогтолцоо, мэдрэлийн тогтолцооны өвчин, яс булчины өвчлөлүүд давамгайлж байсан ба давхацсан тоогоор 327 ажилтан үзлэгт хамрагдсан. 9-11 саруудад: Амьсгалын замын өвчлөл,				

		зүрх судас, хоол боловсруулах эрхтэн тогтолцоо, мэдрэлийн тогтолцооны өвчин давамгайлж байсан ба давхацсан тоогоор 123 ажилтан үзлэгт хамрагдсан.					
Зардал							
Нийт зардал				2720.0			

“Дөрвөлжин” шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах, шохой үйлдвэрлэх төслийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2720.0 төгрөгөөр зарцуулсан байна.

Хүснэгт 6. Нөхөн сэргээлтийн тайлан

Д/Д	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Байгаль орчныг хамгаалахад хэрэгжүүлсэн хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зураг
1.	Төслийн барилга угсралтын ажил дууссаны дараа талбай тэгшлэх	Талбайг бульдозероор тэгшлэх, үр цацахад бэлтгэх	Үйлдвэрийн барилга угсралтын ажил одоогоор бүрэн дуусаагүй байна. 2026 оноос гадна зам талбайн тохижилтыг эхлүүлнэ.	Үйлдвэрийн талбай	Төслийн зардалд тусгагдсан	Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад	
2.	Зүлэгжүүлэх	Олон настын үр авах	Олон наст зүлэгний үр 10 кг худалдан авч нийгмийн хариуцлагын хүрээнд Тайшир сумын ЗДТГ 5 кг үр өгсөн	Үйлдэрийн талбай, сум орон нутаг	320.0	Жилийн турш	
3.	Тэрбум мод	Ногоон байгууламж	Завхан голын эрэг дагуух нөхөн сэргээлтийн талбайд шар хуайс, улиас мод тарив.	Хайлаас 2000 ш	2000ш		

**ТАЙШИР ШОХОЙН ҮЙЛДВЭР “ДӨРВӨЛЖИН” ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ, ШОХОЙ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

		Нийгмийн хариуцлагын хүрээнд	Говь-Алтай аймгийн Тайшир сумын ЗДТГ-т мод хүлээлгэн өгсөн	Хайлаас мод 2000 ш	2000ш		
Нийт төсөв					10320.0		

“Сэнжит худаг” шохойн чулуу, цахиурлаг занарын ордыг ил аргаар ашиглах, цемент үйлдвэрлэх төслийн 2025 онд нөхөн техник болон биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй бөгөөд харин шимт хөрс хуулах ажил хийгдсэн болно. Иймд шимт хөрсний үржил шимийг алдагдуулахгүй тоосжилт үүсгэхгүй байх үүднээс ургамалжуулан хадгалах бөгөөд уг ажилд 10’320’000 төгрөг зарцуулсан.

4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал болон амьдрах орчны нөхцөл илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын гол зорилго оршино.

Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний тайлан

Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж
Биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг биелүүлэх	Говь-Алтай аймгийн Тайшир сумын Галуут болон далан багийн худаг засаж сайжруулах	Хатуугийн усыг хашиж хамгаалах болон Цагаан толгой худгийг засаж сайжруулах барилга байгууламж барих сум орон нутгийн удирдлагуудтай зөвлөлдөж Хуримт багт шинээр худаг гаргаж барилга байгууламжийг барьж гүйцэтгэсэн.	Сум орон нутгийн хэмжээнд	1	25000.0	2025 он
	Техникийн нөхөн сэргээлт	Говь-Алтай аймаг, Тайшир сумтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд далан багийн нутаг дэвсгэрт нийт 7.21 га газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн	Сум орон нутгийн хэмжээнд	1	15532.5	2025 он
		Нийт дүн			40532.5	

ТАЙШИР ШОХОЙН ҮЙЛДВЭРИЙН 2025 ОНЫ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.8-д “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон талбайг нөхөн сэргээнэ” гэж заасан. Цэнгазар компанийн хувьд үйл ажиллагааны хүрээнд эвдэрч доройтсон талбай одоогоор байхгүй байна. Говь-Алтай аймаг болон Тайшир сум, Цэнгазар ХХК-иудын хооронд хийсэн хамтран ажиллах гэрээний хүрээнд аймгийн БО-ны мэргэжилтний заасан талбайд 2025.08.03 – 2025.08.05 хооронд нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй 4 техниктэй 4.98 га талбайг болон нэмэлтээр эвдрэлд өртсөн 2.23 га нийт 7.21 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг амжилттай хийж гүйцэтгэсэн.

Нэмэлтээр хийсэн 2.23 га талбайн солбицолууд

Дугаар	Х координат	Ү координат
1	5,154,870.28	281,134.5
2	5,154,900.48	281,141.26
3	5,154,916.67	281,101.23
4	5,154,884.57	281,094.46

Дугаар	Х координат	Ү координат
1	5,154,722.69	280,715.07
2	5,154,792.81	280,678.14
3	5,147,708.12	280,460.37
4	5,154,762.12	280,405.93

Дугаар	Х координат	Ү координат
1	5,154,915.05	281,960.86
2	5,154,951.46	281,951.09
3	5,154,936.11	281,860.62
4	5,154,903.11	281,842.14

Дугаар	Талбайн хэмжээ (м²)	Талбайн хэмжээ (га)
1	3,570.54	0.357
2	1,350.18	0.135
3	17,383.47	1.738

Техникийн нөхөн сэргээлтийн гарсан зардал

Зардлын төрөл	Дүн (₮)
Цалин (4 өдөр)	10,080,000
Хоол, унд (4 өдөр)	840,000
Түлш	4,612,500
Нийт	15,532,500₮

Ажилсан техникийн мэдээлэл

№	Машин	Нэг өдөр ажиллас	Хоног	Нийт цаг	Өдөрт шатахууны (л)	Нийт шатахууны (4 ун, хоног, л)
1	Ковш	12	4	48	200	800
2	Түлшний машин	4	2	48	20	40
3	Ланд 76	12	4	48	35	140
4	Ланд 79	12	1	48	45	45
НИЙТ						1025


5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН


Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэлт хийх малчин айл 3 байгаа бөгөөд одоогоор 2 өрхтэй уулзалтууд хийж баримт бичгийн бүрдүүлэлтийг хийж байна. 2026 онд зөвшилцөлд хүрсний дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах болно.

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТАЙЛАН

Археологийн хайгуул, тандан судалгааны ажлын үр дүнд ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн урд хэсэгт дугуй хэлбэрийн намхан дардастай, голдоо хонхор булш нэгийг илрүүлэн дурсгалын гадаад зохион байгуулалтад үндэслэн хүрэл, төмрийн түрүү үед холбогдох булш, оршуулгын дурсгал хэмээн урьдчилсан байдлаар үзэж баримтжуулсан бөгөөд олборлолтын талбайгаас баруун урагш байгаа бөгөөд цаашдын үйл ажиллагааны нөлөөлөлд өртөхөөргүй байна.

Зураг 3 Археологийн олдворын байршил





Газар шорооны ажлын үед өмнө нь судалж тогтоож чадаагүй археологийн болон түүх соёлын үлдэц, үнэт зүйлс өртөж болзошгүй. Иймд “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн заасны дагуу түүхийн болоод соёлын өв сангийн зүйлүүд олдох буюу байх магадлал ихтэй бол нэн даруй төслийн үйл ажиллагааг зогсоож, орон нутгийн засаг захиргаа мөн улс төрийн болон холбогдох шинжлэх ухааны судалгааны байгууллагуудад мэдэгдэх үүрэгтэй. Уг үүргээ хэрэгжүүлэн ажилласан.

Түүх, соёлын дурсгал болон ард түмний зан үйлд харшлах зүйлсийг хөндөхгүй байхын үүднээс талбайд орших дурсгалт зүйлст хамгаалалт хийх, ойр орчмоор нь машин техник явуулахгүй байсан.

Хүснэгт 8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний тайлан

Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал Мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зураг
Соёлын өвийн талаарх сургалт, зааварчилгаа өгөх	Уурхайн ажилтнуудад	Ү/А-ны зардлаар	2025 онд уурхай болон үйлдвэрийн хэмжээнд 26 ажилтанд соёлын өвийн талаар сургалт орсон.	
Түүх соёлын дурсгалт газрыг тоногдон дээрэмдүүлэхээс урдчилан сэргийлэх, тэмдэг тэмдэглэгээ хийх, ажиглалт	Дурсгалт газар		Дугуй хэлбэрийн намхан дардастай, голдоо хонхор булш нэгийг илрүүлэн дурсгалын гадаад зохион байгуулалтад үндэслэн хүрэл, төмрийн түрүү үед холбогдох булш,	

хамгаалалтанд авах			оршуулгын дурсгал хэмээн урьдчилсан байдлаар үзэж баримтжуулан хадгалж байна. Тэмдэг тавьсан.	
Төслийн талбайд шинээр газар хөндөх үед соёлын өвд хамаарах эд өлгийн зүйл олдох үед холбогдох археологи, палентлого газарт мэдэгдэх	Газар шорооны ажил хийх талбайд зөвхөн илэрсэн тохиолдолд	Илэрсэн үед ашиглах гэнэтийн зардал учир жил бүрийн БОМТ-ын зардалд тусгаагүй болно.	Төслийн талбайд шинээр газар хөндөх үед соёлын өвд хамаарах эд өлгийн зүйл одоогийн байдлаар олдоогүй байна	
Нийт зардал		0		

Түүх соёлийн дурсгалт зүйлийг хамгаалах хууль тогтоомж, байгууллагын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг үйлдвэр болон уурхайн ажилчдад танилцуулсан.

7.ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН

Тэсэлгээний ажил нь шохойн чулуу, цахиурлаг занаржсан аргиллит зэрэг чулуулагт хийх тул чулуулгийн физик-механик шинж чанарт тулгуурлан үзүүлэлтүүдийг сонгож тооцоолсон. Шохойн чулууны бат бөхийн коэффициент нь профессор М.М.Протодияконовын ангиллаар III бүлэгт буюу хүнд тэслэгдэх зэрэгт орох ба эзлэхүүн жин дунджаар 2.59 тн/м байна

Тэсэлгээнд Анфо болон Эмульсийн тэсрэх бодисыг хэрэглэхээр тооцсон ба 20 жилийн хугацаанд 1.5 сая.м³ уулын цулын материалд 1.1 тонн эмульсийн тэсрэх бодис хэрэглэхээр тооцсон байна.

Шохойн үйлдвэрийн технологийн дамжлагад химийн бодис ашиглахгүй бөгөөд лабораторид химийн бодис ашиглана. Лабораторид 59 нэр төрлийн бодисыг жилд ойролцоогоор 390 кг хуурай бодис хэрэглэхээр тооцсон байна. Химийн бодисын нэр томьёо, зарцуулалтын хэмжээг химийн эрсдэлийн үнэлгээнд нарийвчлан авч үзсэн.

8.ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН

Цэнгазар ХХК-ийн “Дөрвөлжин” шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах, шохой үйлдвэрлэх төсөл нь өөрийн үйл ажиллагаандаа ISO 45001 буюу Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна. Уурхай болон үйлдвэрийн гэнэтийн ослын эрсдэлийн үнэлгээ болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний дагуух тайланг доорх хүснэгтэд хураангуй байдлаар үзүүлэв.

Хүснэгт 9. Осол эрсдэлийн менежментийн тайлан

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хэрэгжилт
Аадар бороо, үер	Үер болон хүчтэй салхи шуурганы дараа уурхайн тээвэрлэлт хийгддэг үйлдвэрийн тоног төхөөрөмжрүү ус орох, сайжруулсан шороон зам эвдрэлд орсон эсэхийг шалгаж, эвдэрсэн тохиолдолд засах.	Жил бүр	Үйлдвэрийн хэмжээнд байгаа үерийн шуудууны цэвэрлэгээг 5, 6, 7 сард 14 хоногт 1 удаа цэвэрлэгээ хийсэн.
Аянга, цахилгаан	Хамгаалах газардуулгын байгууламж буюу тэглэлтийн стандартаар тогтоосон шаардлагыг ашиглалтын үед тогтмол шалгаж нийцүүлж байх.	Жил бүр	Үйлдвэр анх баригдахдаа бүх барилга байгууламждаа газардуулга хийсэн. Үйлдвэрийн цахилгааны хэлтэс газардуулгын хэмжилт, аюулгүй байдлыг хариуцаж ажилласан.
Хүчтэй салхи, шуурга	Байгууламжийн битүүмжийг сайн байлгах, ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл болсны дараа хяналтын үзлэг, техникийн үйлчилгээг хийж өгөх.	Жил бүр	Шинэ 7 хоногийн 1 дэх өдөр болгон 5 хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээг Өргөн үйлдвэр гэсэн Teams-н групп дээр байршуулдаг. Салхи шуурга болсны дараа барилга байгууламж болон техникуудад үзлэг хийдэг.
Аюултай бодисын асгаралт	Химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материалыг зохих газруудад байрлуулах	Жил бүр	Химийн бодис асгарахаас урьдчилан сэргийлж асгаралтын иж бүрдлийг байрлуулсан байдаг ба бүрэн бүтэн байдлыг шалгаж, шаардлагатай хэрэгслүүдийг солих зэргээр тогтмол цэвэрлэдэг.
	Шатах тослох материалын болон хаягдлыг түр хадгалах цэгийг хөрс бохирдохоос хамгаалж бэлтгэх, асгаралтын иж бүрдлийг бэлэн байлгах	Жил бүр	
Хяналтаас гадуурх дэлбэрэлт	Уурхайн талбайд аюулгүй ажиллагааны бүх дүрэм журам болон тэсрэх бодистой холбоотой бусад бүх журмыг дагаж мөрдөх	Жил бүр	Тэсэлгээний аюулгүй байдлын журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
Гал түймэр	Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг байнгийн бэлэн байлгах шаардлага хангаагүй галын хор багаж хэрэгслийг тухай бүрд нь шинэчлэн байрлуулах. Галын хорын хугацааг шалгах	Жил бүр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэс галын хорны бүрэн бүтэн байдал, хүчинтэй хугацааг улирал бүр шалгаж, цэнэглэх засах зэрэг шаардлагатай бүх арга хэмжээг авч ажилладаг.
	Түлшний агуулахын нөөцлүүр сав болон аянга зайлуулагч бүрэн бүтэн байдлыг 14 хоногт 1 удаа шалгах. Ил гал гаргах, оч үсрэхийг хатуу хориглох	Жил бүр	
ЗАРДАЛ		0.0	

7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН

Хог хаягдлын бодлогийг хэрэгжүүлэхдээ компани дараах зураглалд үзүүлсэн урвуу пирамид зарчмыг баримталдаг бөгөөд уг зарчмын хүрээнд нэн тэргүүнд хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин боловсруулалтын хувь хэмжээг нэмэгдүүлэнийг зорилго болгон ашигладаг.

Зураг 5



Хаягдлын менежментийг амжилттай хэрэгжүүлэх гол үндэс нь ангилан ялгах бөгөөд Цэнгазар компанийн хувьд ажлын байр, тухайн нөхцөлөөс хамааран 30 орчим нэр төрөлд ангилан ялгадаг. Эдгээр хаягдлын эцсийн цэг нь хаана хүрэх, хэрхэн устгах эсвэл дахин боловсруулах гэдгээс хамааруулан үндсэн 4 бүлэгт хуваана.

Хүснэгт 10 .Үйлдвэрийн талбай дахь хог хаягдлын ангилал


Устгах	Дахин ашиглах	Дахин боловсруулах	Хадгалах
1. Ахуйн хаягдал 2. Эмнэлгийн хаягдал 3. Нунтаг үнс 4. Бетон зуурмагийн үлдэгдэл 5. Тостой даавуу 6. Химийн бодисын үлдэгдэл	7. Мод 8. Том оврын дугуй 9. Цахилгаан хэрэгсэл 10. Шил 11. Хөөсөнцөр хавтан	12. Хуванцар сав 13. Цаасан хайрцаг 14. Гялгар уут 15. Хуванцар хоолой 16. Төмөр 17. Шуудай 18. Хоолны хаягдал 19. Цахилгааны утас 20. Хатуу хуванцар 21. Гал тогооны тос 22. Техникийн тос 23. Авто машины зай хураагуур 24. Даралтат бодисын төмөр сав	25. Тосны шүүр 26. Химийн бодисын төмөр сав баглаа 27. Химийн бодисын төмөр сав 28. Химийн бодисын үлдэгдэл 29. CO2 шингээгч материал 30. Том оврын дугуй 31. Ахуйн зай хураагуур 32. Принтерийн хор

*Улаан өнгөөр аюултай хог хаягдлыг, хар өнгөөр энгийн ангиллалын хаягдлыг тэмдэглэв.

Төслийн үйл ажиллагаанаасаа гарч буй хог хаягдлын хэмжээг багасгах, эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын


хэмжээг бууруулах, хог хаягдлаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр ажиллаж байна.

Зураг 6. Хог хаягдлын нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө




Хүснэгт 11. Хог, хаягдлын менежментийн тайлан

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Зардал мян/төг	Тоо хэмжээ	Хэрэгжилт	Зураг	Хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Ахуйн	10.1.1 Хог хаягдлын гэрээг орон нутагтай байгуулж, төлбөрийг гэрээний дагуу төлөх	Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	Сард 1 удаа	1000.0	12	Говь – Алтай аймгийн Тайшир сумын ЗДТГ-тай хог хаягдлын гэрээг байгуулж төлбөрийг гэрээний нөхцөлийн дагуу төлж байна. Тайлант онд 1.0 сая төгрөгийн орон нутгийн төсөвт хийсэн байна.		2025 он	Хог хаягдлын тухай хууль
	10.1.2 Хог хаягдлын бүртгэл хөтлөх.	Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	Сард 1 удаа	ҮАЗ	12	Аюултай хог хаягдал болон энгийн хог хаягдлын бүртгэл хөтлөн ажиллаж байна. Харин аюултай хог хаягдлын төрөл болох шатах тослох материалын хувьд тоног төхөөрөмжийн ашиглалт, ээлжит засвар үйлчилгээ болоогүй бүгд шинэ учир өнөөгийн байдлаар тос болон бусад зүйлийн хаягдал гараагүй байна.		2025 он	Хог хаягдлын тухай хууль
	10.1.3 Хог хаягдлыг ангилан ялгах сургалт	Бүх хэлтэс, нэгж	Жилд 1 удаа	ҮАЗ	1	Хог хаягдлын менежмент ба хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөө сэдвээр нийт ажилчдад сургалт оросон.		2025 он	Хог хаягдлын тухай хууль

10.1.4	Хуванцар цуглуулах сав 4ш хийх	Зааварчилгааны байрууд	Жилд 1 удаа	ҮАЗ	1	Хуванцар цуглуулах савны хүртээмжийг нэмэгдүүлэн эх үүсвэр дээр нь ангилан ялгалт хийж байна.		2025 он	Хог хаягдлын тухай хууль
10.1.6	Хог хаягдлаа эх үүсвэр дээр нь хуванцар, шил,лааз, төмөр ширэм, цэвэр цаас, картонин цаас зэргээр ангилан ялгаж, холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулан нийлүүлэх	Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	Сард 1 удаа	-	12	Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж Говь-Алтай аймагт үйл ажиллагаа явуулж буй компанитай хамтран ажиллах гэрээ байгуулж дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг тушааж байна.		2025 он	Хог хаягдлын тухай хууль
10.1.8	Орчны хог хаягдалд тогтмол хяналт тавьж, сар тутам орчны цэвэрлэгээг хийнэ.	Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	Сард 2-3 удаа	ҮАЗ	-	7 хоног бүрийн 5 өдөр 15:00 цагаас үйлдвэрийн дотор, гадна талбайн цэвэрлэгээг хийдэг. Байгаль орчны мэргэжилтэн хяналт тавьж ажилладаг.		2025 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль.
10.1.9.	Хог хаягдлыг БОХ-6.1, БОХ-6.2 маягтын дагуу мэдээллэх	Үйлдвэр болон уурхай ажилчдын кемп	Жилд	-	1	Хог хаягдлын төрөл зүйл, ангилалаар нь БОХ-6.1, БОХ-6.2 маягтын дагуу асуулгыг бөглөн холбогдох газруудад статистик мэдээллийг хүргүүлсэн		2025 он	Хог хаягдлын тухай хууль Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль

ТАЙШИР ШОХОЙН ҮЙЛДВЭР “ДӨРВӨЛЖИН” ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ, ШОХОЙ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Аюултай	10.2.1. Хаягдал зайлуулах гэрээг эрх бүхий этгээдтэй хийх	Аюултай хог хаягдал үүсэх эх үүсвэрүүд	Жилд	ҮАЗ	-	Аюултай хог хаягдлыг шилжүүлэх зайлуулах гэрээг Макс-Өргөө ХХК нь Түмэн эгшиг ХХК-тай байгуулж техник, тоног төхөөрөмжөөс гарсан маслын шүүр, аккумулятор, шатах тослох материал зэргийг шилжүүлэн өгч байна.		2025 он	Хог хаягдлын тухай хууль
Шингэн хаягдал	10.3.1. Нүхэн жорлонг “Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага” MNS 5924 : 2015 стандартын дагуу байгуулах,	Үйлдвэр болон уурхай ажилчдын кемп	Жилд	500.0	1	Үйлдвэрийн талбайд байсан нүхэн жорлонг буулгаж оффис болон лабораторын барилгад боловсон ариун цэврийн өрөөг хийсэн			
	Шингэн хог хаягдал зайлуулах гэрээг байгуулан зөөвөрлүүлэх	Үйлдвэр болон уурхай ажилчдын кемп	Жилд	ҮАЗ	1	Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд үйл ажиллагаа явуулдаг гахайн фермд хоолны хаягдал, малын яс мэт бүх төрлийн хүнсний хаягдал бүтээгдэхүүнийг нийлүүлэн хуурай,		2025 он	Хог хаягдлын тухай хууль

	Хоолны үлдэгдлийг гахайн аж ахуйтай гэрээ байгуулан нийлүүлэх	Үйлдвэр болон уурхай ажилчдын кемп	Жилд	ҮАЗ	1	шингэн гэсэн төрлөөр ангилан ажиллаж байна.		2025 он	Хог хаягдлын тухай хууль
Ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	Хатуу шингэн хог хаягдлын цэгүүдэд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	Хог хаягдлын цэг	Улиралд 1 удаа	80.0	4	Мастерфүүдс ХХК-ний эрүүл ахуйч, уурхайн эмч нарын өгсөн зөвлөмж зааварчилгааний дагуу хатуу шингэн хог хаягдлын цэгүүдэд 10%-ийн жавелин уусмалаар ариутгал халдваргүйжүүлэлтийг чанарын өндөр түвшинд тогтмол хийж байна.		2025 он	
Нийт							1580.0		

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал нь дээрх хүснэгтэд тооцоолсноор жилд 1,580,000 төгрөгийг зарцуулсан.

8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар тухайн төслийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг төсөл хэрэгжүүлэгчид өгөгдсөн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байна.

Хуулийн дээрх заалтыг удирдлага болгон төслийг хэрэгжүүлэх явцад төсөл хэрэгжүүлэгчээс байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний үр дүн, төслийг хэрэгжүүлж буй сумын нутаг дэвсгэрт бий болж болзошгүй өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор хяналтын үзүүлэлтүүд, байршил, хийх хугацаа, зардал, баримтлах стандарт, аргачлалыг тодорхойлж энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.

Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь төслийн нөлөөллийн болон нөлөөлөлд өртөж болзошгүй бүс нутагт гарч болзошгүй өөрчлөлтүүдийг эрт тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг илтгэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллага, нутгийн оршин суугчдад байгаль орчин, амьдрах орчны өөрчлөлтийн талаар бодит мэдээлэл өгөх үндсэн зорилготой.

БОХТ болон ОХШХ-ийн хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гаргаж төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн захиргаа, ойр орчмын нутаг дэвсгэр дэх иргэдэд танилцуулах тэдний саналыг нэгтгэн тусгах ажлыг зохион байгуулах, оролцогч болон сонирхогч талуудад мэдээллийг ил тод байлгах.

ГовьАлтай аймгийн Тайшир сумын нутаг дэвсгэрт байрлах MV-017689 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Тайшир шохой” төслийг хэрэгжүүлэгч “Цэнгазар” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу төслийн Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн байгаль орчны аудитыг “Эко Вишн” ХХК-р хийлгүүлсэн.

Байгаль орчны аудитын тайлангийн зургууд



“ЭКОВИШН” ХХК
Байгаль орчны аудитын мэргэжлийн
байгууллага

Байгаль орчны аудит төсөл дээр хийсэн огноо:	2025-06-14 ~2025-07-01
Газар дээрх аудитын нээлтийн хурал хийсэн огноо:	2025-06-14
Газар дээрх аудитын хаалтын хурал хийсэн огноо:	2025-06-15
Тайланг эхний байдлаар хүлээлгэн өгсөн огноо:	2025-06-27
Тайланг эцсийн байдлаар хүлээлгэн өгсөн огноо:	2025-07-01


Тайланг эцсийн байдлаар хүлээлгэн өгсөн:

Тайлангтай танилцсан:

Тайланг эцсийн байдлаар хүлээн авсан:



Ж.БАЯСГАЛАН
“ЭКОВИШН” ХХК АХЛАХ
АУДИТОР



Х.ТОМОРБААТАР
“ЦЭНГАЗАР” ХХК-ийн
ҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М.ВАТСАЙХАН
“ЦЭНГАЗАР” ХХК-ийн
ҮЙЛДВЭРИЙН ЗАХИРАЛ

Аудиторын дүгнэлт

“Цэнгазар” ХХК-ийн “Дөрвөлжин шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах, шохой-цементийн үйлдвэр” төслийн үйл ажиллагаа нь Монгол Улсын байгаль орчны холбогдох хууль, дүрэм, журам, стандартаар тавигдаж буй шаардлагад хэр нийцэж буйг тогтоох зорилгоор байгаль орчны аудитыг (цаашид аудит гэх) 2025 оны 06 дугаар сарын 14-өөс 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

“Цэнгазар” ХХК-ийн MV-017689 /484 га/ тоот тусгай зөвшөөрөлтэй талбай нь Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутаг дэвсгэрт орших ба Улаанбаатар хотоос баруун урагш 1020 орчим км, Алтай хотоос зүүн хойш 40 км, Тайшир сумын төвөөс баруун урагш 10.6 км-т байрладаг. Тус төсөл нь 2023 оны 5 сараас барилга угсралтын ажил эхэлсэн бөгөөд ашиглалтанд орох хугацаа урьдчилсан байдлаар 2025 оны 3-р улиралд гэж төлөвлөгдөж байна. Энэхүү тайланд уурхайн зүгээс байгаль орчны чиглэлээр 2023-2025 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааг хамруулсан бөгөөд байгаль орчны удирдлагын тогтолцоо, агаарын чанар, газар ашиглалт, хөрс хамгаалал, ус ашиглалт, биологийн төрөл зүйл, хог хаягдлын менежмент, оролцогч талуудад тайлагнах зэрэг сэдвийн хүрээнд хийв.

Байгаль орчны аудитын үйл ажиллагааны хүрээнд 7 чиглэлээр 98 шалгуур үзүүлэлтийг гарган үнэлэв. Нийт шалгуур үзүүлэлтүүдийн:




- 83 нь биелсэн /84.7 %/;
- 8 нь бүрэн бус /8.2 %/;
- 7 нь биелээгүй /7.1 %/ ангиллаар нотлогдон гарлаа.




Өөрөөр хэлбэл, “Цэнгазар” ХХК нь хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд хүлээх үүргээ 88.8 % буюу сайн үнэлгээтэй биелүүлж байна. Аудитын үнэлгээгээр бүрэн бус шалгуурууд буюу үл тохиролд эрсдэлийн үнэлгээ хийж үзэхэд 3 нь бага эрсдэлтэй, 9 нь дунд эрсдэлтэй, 2 нь их эрсдэлтэй гарсан. Эдгээр үл тохирлыг хэрхэн залруулах тухай 34 зөвлөмж боловсруулсан бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан 14 зөвлөмжтэйгөөр оруулж, хэрэгжүүлэхэд дөхөмтэй болгох үүднээс ойрын хугацаа, дунд хугацаа, урт хугацаанд хэрэгжүүлэх гэж ангилан орууллаа. Зөвлөмжид тусгасан арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх хугацааг аудит хийлгэгч талтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр тогтоосон болно.

Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг 2026 оны 4 дугаар улиралд багтаан, Аймгийн байгаль орчны газарт хүргүүлэх үүргийг аудит хийлгэгч хариуцна.




Ж. Баясгалан
“Эковишн” ХХК-ийн
байгаль орчны ахлах аудитор











ХӨРСНИЙ ШИНЖИЛГЭЭ








ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛИЙН ШИНЖИЛГЭЭ 2025.07.08



ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛИЙН ШИНЖИЛГЭЭ 2025.11.17



2025 онд гэрээ, зөвшөөрлийн дагуу төлбөр төлсөн баримт

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Хугацаа	Мөнгөн дүн (мян.төг)
1	Газрын төлбөр (Үйлдвэрлэлийн бүс 24 га)	1	2025.04.15	960.000
2	Газрын төлбөр (Үйлдвэрийн бүс 24 га)	1	2025.06.18	960.000
3	Газрын төлбөр (Үйлдвэрийн бүс 24 га)	1	2025.10.01	960.000
4	Газрын төлбөр (Үйлдвэрийн бүс 24 га)	1	2025.10.09	960.000
5	Газрын төлбөр (Уурхайн бүс 542.21 га)	1	2025.02.27	118.400.00
6	Газрын төлбөр (Уурхайн бүс 542.21 га)	1	2025.02.27	1.393.488.00
7	Газрын төлбөр (Уурхайн бүс 542.21 га)	1	2025.02.27	139.568.00
8	Газрын төлбөр (Уурхайн бүс 542.21 га)	1	2025.02.27	2.305.696.00
9	Газрын төлбөр (Уурхайн бүс 542.21 га)	1	2025.04.15	132.974.00
10	Газрын төлбөр (Уурхайн бүс 542.21 га)	1	2025.04.15	1.327.633.00
11	Газрын төлбөр (Уурхайн бүс 542.21 га)	1	2025.04.15	112.806.00
12	Газрын төлбөр (Уурхайн бүс 542.21 га)	1	2025.04.15	2.196.730.00
13	Хог хаягдлын хураамж	1	2025.11.20	1000.000.00
14	Усны төлбөр	1	2025.11.20	274.955.00
Нийт		14		12.842.250

9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЙЛАН

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах, төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгчийн удирдлага хүлээнэ.

Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын тайлан

Д/д	Төлөвлөсөн арга хэмжээ	Төсөв (мян.төг)	Хэрэгжүүл эх хуваарь	Хэрэгжилт	Хариуцагч	Баримтлах хууль журам, стандарт
1.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОУАӨЯ-ны ХБОБХГ-аар батлуулж ажиллана.	Дотоод төлөвлөлтө өр	2025 он	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОУАӨЯ-ны ХБОБХГ-аар батлуулж ажилласан.	Байгаль орчны мэргэжилтэн	“Байгаль хамгаалах тухай” хууль БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29 А-618 тоот тушаал; -
2.	Байгаль орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдлын харилцааг зохицуулах дотоод дүрэм, журамтай болох	Дотоод төлөвлөлтө өр	2025 он	Тайшир сумын Засаг Даргын тамгийн газартай 4 удаагийн уулзалт хийсэн. 2025 оны 10 сарын 24-ний өдөр Тайшир сумын багийн хурал дээр очиж Хог хаягдал хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөө сургалтыг багийн нийт иргэдэд орсон.	Байгаль орчны мэргэжилтэн	
3.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар жилд 2 удаа сургалт сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	Дотоод төлөвлөлтө өр	2025 он	Говь-Алтай аймгийн ОБГ-тай хамтран галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт төлөвлөж зохион байгуулсан	Байгаль орчны мэргэжилтэн	
4.	Галын дүгнэлт гаргуулах	Дотоод төлөвлөлтө өр	2025 он	Говь-Алтай аймгийн ОБГ-аас үзлэг шалгалтыг хийн дүгнэлт гаргуулсан	Байгаль орчны мэргэжилтэн	
5.	Орон нутгийн захиргаа, Байгаль орчны байгууллага ажлын хэсгийн дүгнэлт, шаардлагыг тухай бүр хэрэгжүүлэх арга хэмжээ авах	Дотоод төлөвлөлтө өр	2025 он	Тухай бүрт өгсөн үүрэг чиглэлийн дагуу арга хэмжээ авч үйл ажиллагааны чиглэлдээ тусган ажиллаж байна.		
Нийт төсөв		0.0				

ТАЙШИР ШОХОЙН ҮЙЛДВЭР “ДӨРВӨЛЖИН” ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ, ШОХОЙ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1. АГААРЫН ЧАНАР								
1	Агаарын чанарын (NO2, SO2, PM2.5, PM10 CO2) Дуу шуугиан шинжилгээ хийлгэж байх	-Ил уурхайн олборлолт хийх талбайд -Технологийн замын ойролцоо -Шохойн үйлдвэр -Кемп	5, 10 сард 2 удаа	тодорхой цэгт	24500 60000	196.0 480.0	БОАЖЯ-ны сайдын 2023 оны А/643дүгээр тушаал аар баталсан “Орчны чанарын хяналт шинжилгээний ажил, үйлчилгээний үнэ тариф” тогтоолоо.	-MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага -MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага -MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, төвшний хэмжээ -MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
2	Яндангийн хаягдал утаанд агуулагдах бохирдуулагчид буюу CO, SO2, NO2,үнс	Уурын зуух орчимд	Улирал бүр	1	220,000	220.0		- MNS 5919:2008 Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын бус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга
нийт						896.0		
2. ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УСНЫ ЧАНАР								
1	Усны ерөнхий химийн үзүүлэлтүүд	-1 гүний худаг -Дэлэнтийн худаг -Баарангийн булаг -Завхан гол	6 сард	4	65000	260.0	Шинжилгээний үр дүнг мэргэжлийн хөндлөнгийн лаборатори байх нь зүйтэй.	-MNS 4586:98 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага, -MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүйн байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага. Чанар, аюулгүй байдлын үнэлгээ -MNS 6148:2010 Усны чанар. Газар доорх усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2	Гадаргын болон газрын доорх усны бохирдлын хяналт хийх	-1 гүний худаг -Дэлэнтийн худаг - Баарангийн булаг	Улирал тутам	4	55000	220.0		
3	Газрын доорх усны бактериологийн бүрэн шинжилгээ.	-Завхан гол -Эзэмшлийн 1 худаг -Дэлэнтийн худаг -Баарангийн булаг		3	30000	90.0		
4	Газрын доорх усны хүнд металлын шинжилгээ.	-Завхан гол	9 сард	1	SJS лаборторид шинжлүүлэх			
нийт						570.0		
3. ХӨРС, ХӨРСӨН БҮРХЭВЧ								
1	Хөрсний ерөнхий шинжилгээ (Агрохими, Механик бүрэлдэхүүн)	Уурхайн ухаш орчим дурын 1 цэг	5,10 сард	2	68500	137.0	Шинжилгээний үр дүнг мэргэжлийн хөндлөнгийн	- MNS 5850:2019, Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.

**ТАЙШИР ШОХОЙН ҮЙЛДВЭР “ДӨРВӨЛЖИН” ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ, ШОХОЙ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2	Хөрсний бохирдлын шинжилгээ /эрүүл ахуй, хүнд металл/	Ажилчдын кемпийн хашаанд		3	45000	135.0	лаборатори байх нь зүйтэй.	
		Нүхэн жорлон болон баригдаж буй боловсон ОО орчим						
		ШТС (Техникийн засвар үйлчилгээ хийх цех, газарт.)						
3	Хөрсний цацрагийн шинжилгээ	Ил уурхайн олборлолт хийж буй талбайгаас		2	5000	10.0		
		Уурхай орчмын хөрснөөс						
нийт						282.0		
4. Төмилөлт								
1	Мэргэжилтэн	Судалгаа хийх /ургамал , хөрсний мониторинг гэх мэт/	9 сард	3 хүн 2 өдөр	35000	210.0		
Хяналт мониторингийг хэрэгжүүлэх гүйцэтгэлийн зардал						1 958 000 төгрөг		

10. АЙМАГ СУМ, ОРОН НУТГИЙН ТӨР ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН
ШААРДЛАГААР ХИЙСЭН АЖИЛ БОЛОН НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ИРГЭДЭД
ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, БИЕЛЭЛТ

2025 онд Хар ус нуур завхан голын усны сав газрын захиргаан болон аймгийн Онцгой байдлын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар зэрэг байгууллагуудаас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтууд хийгдсэн. Шалгалтын дагуу ирсэн зөвлөмж болон албан шаардлагын дагуу хариу арга хэмжээг авч хариуг хугацаанд биелүүлж ажилласан байна. Барилгын ажлын явц, бомтөлөвлөгөөний хэрэгжилт бусад ажлуудын талаар сумын засаг дарга, бохуб, байгаль хамгаалагч нартай байнгын харилцаа холбоотой байж ажлаа уялдуулан ажиллаж байна.

Нийгмийн хариуцлагын гэрээг 2024 оны 03 сарын 01-ны өдөр захирал болон тайшир сумын засаг дарга нар харилцан тохиролцож байгуулсан. Өсвөр үеийнхний бие бялдрыг хөгжүүлэх, чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх, биеийн тамирын сонгоныг хичээллүүлэх багшийн урамшуулалд 1500.0 мян.төгрөгийг зарцуулав.

Завхан голоос хүлэмж рүү суваг татах, цамхаг угсрахад техник, тоног төхөөрөмжийн туслалцаа үзүүлсэн.



Шалгалтын дагуу ирсэн зөвлөмж болон албан шаардлагын дагуу хариу арга хэмжээг авч хариуг хугацаанд биелүүлж ажилласан байна. Барилгын ажлын явц, бом төлөвлөгөөний хэрэгжилт бусад ажлуудын талаар сумын засаг дарга, бохуб, байгаль хамгаалагч нартай байнгын харилцаа холбоотой байж ажлаа уялдуулан ажиллаж байна. Тайшир сумын 3 багийн эмчид анхан шатны түргэн тусламжийн хөнгөн тэрэг олгосон Тайшир Шохойн үйлдвэр нь нийт 120 гаруй хүн ажиллаж байгаагаас сум орон нутгийн 60 гаруй хүн ажиллаж байна. Энэ нь ажиллах хүчний 50-иас дээш хувийг бүрдүүлж байна.

2025 оны 04-р сарын 10-ны өдөр говь-алтай аймгийн засаг дарга, тайшир сумын засаг дарга, цэнгазар ххк-ий хооронд ашигт малтмалын тухай хуулийн 42-р зүйлийн 42.1 хэсэг зг-ийн 2016 оны 179-р тогтоолыг үндэслэн 3 талт нийгмийн хариуцлагын гэрээ байгуулсан.

ТАЙШИР ШОХОЙН ҮЙЛДВЭР “ДӨРВӨЛЖИН” ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ, ШОХОЙ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Мунгалар - ХХК-тай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний хавсралт

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ

2025 оны 04 дүгээр сарын 11 өдөр Үлэнбаатар хот

Гэрээний дугаар: _____

Гэрээ байгуулсан талууд: Говь-Алтай аймгийн Засаг дарга, түүнийг төлөөлж Говь-Алтай аймгийн Засаг дарга Г.Чинбат, сумын Засаг дарга _____, нөгөө талаас ашигт малтмалын _____ дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшсэн "ХХК-ийн захирал/гүйцэтгэх захирал/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэмжих нэгж	Тоо	Хөрөнгө, дэмжлэг, хандив (сая. төг)
Нэг. Орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдийн амьдрах орчныг сайжруулах				
1	"Говь-Алтай 60" эрүүл мэндийн хэлтсний хүрээнд бөгөөд зөвхөн суудлын авто машинд хангах	ш	3	95,0
2	Боловсролын чанарыг сайжруулах хэлтсний хүрээнд бөгөөд суурьчлагч урьдчилсан	ш		
3	Сүү хэлтсний хүрээнд харьяа сумын хүүхдүүдэд өдөрт 200г сүү олгоход дэмжлэг үзүүлэх	Литр		
4	Төрийн албан хаагчдыг орон сууцруулах арга хэмжээний хүрээнд төрийн албан хаагчид дэмжлэг үзүүлэх	ТАХ-ийн тоо		
5	Найт ахуйн байрны 40-өөс доошгүй хувьд орон нутгийн иргэдээс авч ажиллуулах	Ажилтан	+50	
Хоёр.Бусад				
1	<i>Хиймэл аугуйн сарсан</i>	ш	1	35,0
2	<i>(Ажлын гал)</i>	ш	1	10,0
3	<i>Ажлын гал</i>	ш	1	10,0
4				
5				

Жич: Харилцан токиролсны үндсэн дээр 2025 оны 04-р сарын 11 өдөр төрийн дэмжлэг хөрөнгө оруулалтыг авч, сумын хөгжлийг ороон дэмжүүлнэ.

ЗАСАГ ДАРГА Г.ЧИНБАТ

СУМЫН ЗАСАГ ДАРГА Г.ЧИНБАТ

Утас: 3301111111

Хаяг: *Мунгалар*

Засаг даргын Тамгын газар, компани болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

7.2.Хороо гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажиллана. Хорооны ажиллах журмыг талууд хамтран батална.

НАЙМ МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

8.1.Гэрээг тайлбарлах болон гэрээний хэрэгжилтэд холбоотой маргаан, зөрчилгүй тухай бүр, эе зүйгээр шийдвэрлэхийг зорьно.

8.2.Хэрэв маргаантай асуудлаар талууд токиролцонд хүрээгүй токиолдорд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ЕС. БУСАД ҮЙЛ

9.1.Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

9.2.Давждаггүй хүчин зүйлсийн үрэлээс гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно. Энэ тухайгаа нэг сарын өмнө нөгөө талд албан бичгээр мэдэгдэнэ.

9.3.Талууд харилцан токиролцоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.4.Хэрэв гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардлага гарвал нөгөө талдаа 30 хоногийн өмнө харилцан бичгээр мэдэгдэнэ. Оруулсан нэмэлт өөрчлөлтийг гэрээнд хавсаргаснаар нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

9.5.Гэрээ Монгол хэл дээр 3 хуви үйлдэх бөгөөд Компани нь 1 хуви, аймга, сумын удирдлага 1, 1 хуви, тус бүр хадгална.

9.6.Энэхүү гэрээ нь... хуудас хамралттай болно.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.ЧИНБАТ

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАНГАМЫН ГАЗАР Г.ЧИНБАТ


СУМЫН ЗАСАГ ДАРГА Г.ЧИНБАТ

СУМЫН ЗАСАГ ДАРГА Г.ЧИНБАТ

ХЯНАСАН: АЗДТ-ЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Тайшир сумын Хуримт багийн нутаг дэвсгэрт гүний худаг гаргах ажил хийгдсэн. Мөн худгийн байр бэлэн болсон бөгөөд 2026 оны 1-р улиралд байршуулна.



ДҮГНЭЛТ

“Цэнгазар”ХХК нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Дөрвөлжингийн уурхайн байгаль орчны суурь судалгаа, нарийвчилсан үнэлгээ, газрын төлөв байдлыг хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэн уурхайн болон үйлдвэрийн орчмын бохирдсон хөрсийг цэвэршүүлэх, шимт хөрсний хадгалалт, техникийн нөхөн сэргээлтийг хийж буйн дээр байгаль орчныг дүйцүүлэн хамгаалах ажлыг урт болон дунд хугацааны төлөвлөгөөний үндсэн дээр хэрэгжүүлж, уг ажлын хүрээнд Тайшир суманд 2 га талбайд мод суулгац тарих, ургамал, амьтны судалгаа хийх, хогийг цэвэрлэх, байгаль орчны мониторингийн судалгаа хийх, байгалийн унаган төрхийг хадгалах хамгаалахтай холбоотой олон ажлыг төлөвлөн хэрэгжүүлж ирлээ. Уурхайн үйл ажиллагааны нөлөөллийг багасгах гол хүчин зүйлийн нэг болох тоосжилт дарах зорилгоор үйлдвэрийн бүсд тогтмол усалгаа хийж байгаагийн дээр хог хаягдлийн системт менежментийн төлөвлөгөөг эхлүүлэн ажиллаж байна. Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 600 гаруй шар хуайс, улиасны тарьц суулгацыг тарьж 85%-ийн ургалттай байна.

Говь-Алтай аймгийн Тайшир сумын орон нутгийн захиргаатай хамтран ажиллаж

нийгмийн хариуцлагын хүрээнд ирээдүйн спортлог иргэнийг бүтээхэд хувь нэмэр оруулан биеийн тамирийн багшийг цалинжуулан сагсан бөмбөгийн клубийг хичээлүүлэн 70 гаруй сурагчийг хамруулав. Мөн тус сумын 100 жилийн ой болж буйтай холбоотой дүүрэгч материал болох хайрга, бетон зуурмаг нийт 60 м³ хандивласан байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Төслийн Техник эдийн засгийн үндэслэл
2. Төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээгээний дүгнэлт
3. Төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээний тайлан
4. Төслийн 2025 оны уулын ажлын төлөвлөгөө
5. 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А-618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
6. Байгаль орчин ногоон хөгжлийн яамны вэб сайт –www.met.gov.mn
7. Эрдэс баялаг, эрчим хүчний яамны вэб сайт – www.energy.gov.mn
8. Ашигт малтмалын газрын вэб сайт – www.mrpam.gov.mn
9. Эрхзүйн мэдээллийн сайт – www.legalinfo.mn
10. Говь-Алтай аймгийн вэб сайт – www.govi-altai.gov.mn

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Улсын бүртгэлийн гэрчилгээ

Хавсралт 2. Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл